



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/60

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн босго үнэ шинэчлэн батлах тухай 124 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хог зайлуулалтын зардалд шатах, тослох материал” нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “БМБХ” ХХК-ийг сонгон 28,986,000 (хорин найман сая есөн зуун наян зургаан мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээний дагуу үзүүлэлтэд заагдсан чанарын шаардлага хангасан түлш, шатахуун нийлүүлэхийг “БМБХ” ХХК-ний захирал (Н.Мэндсайхан)-д даалгасугай.

3. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), Хот тохижуулах газрын дарга (Д.Очбадрах) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ